

БАТЛАВ  
НИЙТЛЭГ ҮЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ЭРДЭНЭБИЛЭГ

2018 оны ..... сарын .....өдөр

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

2018 05-р сарын 08 өдөр

Улаанбаатар хот

1. Зорилго:

Зоогийн газар, цайны газруудын эрүүл ахуй, хоол үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллыг шалгаж, зөрчил дутагдал, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

2. Хамрах хүрээ:

Нийслэлийн засаг захиргааны 1, 2, 5-р байруудад байрлах зоогийн газар, цайны газрууд

3. Хугацаа:

2018 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс 05 дугаар сарын 18-ны өдрүүдийн хооронд

4. Ажлын хэсэг:

|                                 |              |
|---------------------------------|--------------|
| Дотоод хяналт хариуцсан ажилтан | Ч.Шинэчимэг  |
| Үйлчилгээний албаны дарга       | Л.Уранхайч   |
| Их эмч                          | Н.Энхзаяа    |
| Сантехникийн инженер            | Б.Доржбалжир |

5. Шалгах чиглэлүүд:

5.1 Гал тогооны ерөнхий эмх цэгц, цэвэрлэгээ үйлчилгээний чанар

5.2 Ажилчид зоогийн газарт өдөр тутам дагаж мөрдвөл зохих хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны байдлыг сахин мөрдөж байгаа эсэх, ажлын хувцасны жигдрэлтийг шалгах

5.3 Гал тогооны хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих

5.4 Хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуй болон өдөр тутмын хоолны дээж авалт, тэмдэглэл хөтөлж байгаа байдалд тавих хяналт

5.5 Хүнсний бараа материалын хадгалалт, хамгаалалт

6. Шалгалтын дүн:

Үйл ажиллагааг дүгнэн, илэрсэн зөрчил дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгуулах, доголдож байгаа үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийн, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулж удирдлагад танилцуулан батлуулж шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ЗООГИЙН ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД ХЯНАЛТЫН ТАЙЛАН

2018.05.21

Улаанбаатар хот

Зорилго:

Зоогийн газар, цайны газруудын эрүүл ахуй, хоол үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллыг хянаж, зөвлөгөө өгөх

Хяналт хийх ажлын хамрах хүрээ:

Гал тогооны өрөөний эмх цэгц, цэвэрлэгээ үйлчилгээ

Гал тогооны хэвийн үйл ажиллагаа

Ажлын хувцас болон ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар мөрдөж байгаа эсэх

Хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт

Шалгасан хугацаа:

2018 оны 05 дугаар сарын 14, 15, 16-ны өдрүүд

Дотоод хяналт хийсэн албан тушаалтан:

Ерөнхий ня-бо С.Цогзолмаа

Дотоод хяналт хариуцсан ажилтан Ч.Шинэчимэг

Үйлчилгээний албаны дарга Л.Уранхайч

Их эмч Н.Энхзаяа

Технологич С.Алтанцэцэг

Сантехникийн инженер Б.Доржбалжир

Дотоод хяналтанд хамрагдсан нэгж, албан тушаалтан:

Хангарди зоогийн газар, НЗД-ын Тамгын газрын цайны газар,

УБ чуулгын цайны газар

Шалгалтын үр дүн:

Гал тогооны үйл ажиллагаа, эмх цэгц, цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт хийхэд үйл ажиллагаа хэвийн, цэвэрлэгээ үйлчилгээ тогтмол, өдөр тутмын хоолны дээж авалт, бичилт хийгддэг ололттой сайн талууд байгаа хэдий ч дараах

- хөргөгч, хөлдөөгчийн заалтыг бүртгэлийг тогтмол биш, хөргөгчинд байгаа хүнсний бүтээгдэхүүнийг ангилаагүй
- ариутгалын бодис ашиглах заавар байрлуулах
- цэвэрлэгээг хуваарийн дагуу хийх
- хог хаягдлын савыг хаягжуулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дүгнэлт:

Зоогийн газарт цэвэрлэгээ хийх зааврыг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд зарим сав, агуулхын тавиуруудыг хаягжуулан жигдрүүлсэн. Хүнсний бүтээгдэхүүн хадгалах хөлдөөгч, хөргөгчийг дугаарлан хаягжуулж, температур хэмжигч байршуулснаар заалтыг тогтмол хянаж бүртгэл хөтлөлт хийж байна. Ариутгалын бодис хлорамин, жавеолиныг ашиглах заавар, гар ариутгагч зэргийг угаалтуурын орчим байршуулсан. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллалаа.

Цаашид анхаарах асуудлууд:

- Мэргэжлийн байгууллагаас сургалт авах

- Зоогийн газарт мөрдөгдөх, мөн хүнсний бүтээгдэхүүний ул мөрийг тогтоох бүртгэл хөтлөлтийг хийж хэвших
- Ариутгалын бодисыг зааврын дагуу ашиглаж хэвших, ариутгалыг тогтмол хийж тэмдэглэл хөтлөх
- Зоогийн газрын бүх ажилчдыг жилийн 2-р хагаст эрүүл мэндийн үзлэгт хамруулах

Тайлан бичсэн:

Дотоод хяналт хариуцсан ажилтан

Ч.Шинэчимэг

2018.05.21